

БАЯНТАЛ СУМЫН 2023 ОНЫ 08 ДУГААР САРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МЭДЭЭ

2023.08.25

Баянтал

Удирдлага зохион байгуулалтын хүрээнд:

- Эс Эм стар Геойд ХХК гүйцэтгэсэн Баянтал сумын газарзүйн нэрийн хээрийн тодруулалтын ажлыг Засаг даргын захирамжаар хүлээж авав.

- Бэлчээрийн газрын өөрчлөлтийн цото мониторингийн аргаар үнэлэх журмын дагуу сумын Засаг даргын захирамжаар ажлын хэсэг байгуулж, 12 цэгт мониторинг хийж, үнэллээ.

- Сумын Засаг даргын зөвлөл хуралдаж, гамшгийн зардлаас урьдчилан сэргийлэх болон хяналтын постод ажилласан албан хаагчийн томилолт, хоол, халдвар хамгааллын зардал болон Засаг даргын нөөцөөс 1 албан хаагчийг шагнах, Нүүдэлчин Монгол наадамд оролцох зардлыг, ИТХуралд 5 асуудлыг хэлэлцүүлэхээр тус тус шийдвэрлэв.

- Баянтал сум 2023 оны 08 сарын 23 ны өдөр Сумын Иргэдийн төлөөлөгчдийн ээлжит хуралдаан болж, Сумын Засаг даргаас өргөн барьсан 5 асуудлыг хэлэлцэж, 1 асуудлыг хойшлуулж, 4 асуудлыг дэмжиж баталсан байна. Тухайлбал

- Сумын 2023 оны Газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд нэмэлтээр өөрчлөлт оруулах газрууд
- Амьжиргаа дэмжих зөвлөлийг шинэчлэх тухай санал
- Сумын 2024 онд Баянтал сумын 30 жилийн ойг тэмдэглэх бэлтгэл ажлыг хангах ажлын хэсэг байгуулах санал
- 2023 оны төсөвт нэмэлт тодотгол хийх
- Сумын хоршоог хөгжүүлэх сангийн хөнгөлөлттэй зээлд хамрагдах төсөл сонгон шалгаруулах тов тогтоох тухай
- Газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд нэмэлтээр өөрчлөлт оруулах асуудлыг хуралдааны өмнөх өдөр аймгийн Газрын харилцаа барилга хот байгуулалтын газраас ирүүлсэн чиглэлийн дагуу хэлэлцүүлгийн хойшлуулахаар шийдвэрлэж, сумын амьжиргаа дэмжих зөвлөл, 2023 оны төсөвт нэмэлт тодотгол, Сумын хоршоог хөгжүүлэх сангийн хөнгөлөлттэй зээлд хамрагдах төсөл сонгон шалгаруулах тов тогтоох асуудлыг шийдвэрлэлээ.
- 2023 оны төсөвт нэмэлт тодотгол хийх асуудлыг хүрээнд Орон нутаг хөгжил санд 71 сая төгрөг нэмж батлагдсаныг 2024 онд хийгдэх ажлын зураг төсөв, Наадмын талбайн өргөтгөлийн үргэлжлэл, Агропаркийн талбайд худаг гаргахаар 3 санал оруулсныг дэмжин баталсан байна.

- "НҮҮДЭЛЧИН" Дэлхийн соёлын фестивальд Говьсүмбэр аймаг амжилттай оролцлоо. Монгол Улсын Засгийн газраас 2023-2024 оныг "Монголд зочлох жил" болгон зарласантай холбогдуулан соёлын биет бус өвийн их наадам "Нүүдэлчин" дэлхийн соёлын фестиваль хоёр дахь жилдээ зохион байгуулагдсан байна. Тус фестивальд Баянтал сумаас сумын Засаг даргын Тамгын газар, Соёлын өвийн өвлөн уламжлагчид, Сумын соёлын төв 2023 оны 8 дугаар сар 17-18ны өдрүүдэд оролцсон

- Сумын өвөлжилтийн бэлтгэл ажил хангах төлөвлөгөө, ажлын хэсгийн сумын Засаг даргын захирамжаар байгуулж, аж ахуй нэгжүүдэд хүргүүлээд байна.

- ОХУ-аас БНХАУ-тай хийн дамжуулах хоолойн маршрутын дагуу Баянтал суманд ачилт буулгалтын талбай байгуулах ажлын хэсэг Баянтал суманд ажиллан судалгаа хийж, харилцан мэдээлэл солилцож, шаардлагатай мэдээллийг өгсөн.

Төсөв хөрөнгө оруулалтын хүрээнд:

- Сумын татварын орлого 165,755.3 мянган төгрөг, Аймгийн төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг 1,100,630.5 мянган төгрөг, Сумын орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлэг 401,145.6 мянган төгрөг, Сумын төсвийн 2022 оны давсан орлого, хэмнэгдсэн зардал 12,080.6 мянган төгрөг, Сумын Орон нутгийн хөгжлийн сангийн 2022 оны дансны үлдэгдэл 97,766.2 мянган төгрөг, Хоршоо хөгжүүлэх сангийн 2022 оны дансны үлдэгдэл 20,559.9 мянган төгрөг, Хоршоо хөгжүүлэх сангийн 2023 оны орлогын төлөвлөгөө 40,000.0 мянган төгрөг нийт Сумын 2023 оны төсвийн санхүүжүүлэх эх үүсвэрийг 1,837,938.1 мянган төгрөг баталсан.

- Орон нутгийн хөгжлийн санд 71 сая төгрөгөөр нэмэгдүүлж 517,911.8 сая төгрөгөөр баталсан. Үүнээс Шилжих хөрөнгө оруулалтын 4 ажилд 93.5 сая, шинээр эхлэх 4 ажилд 77 сая, Их засвар 3 ажилд 180.8 сая, Тоног төхөөрөмжийн 3 ажилд 89.9 сая, хөтөлбөр төсөл арга хэмжээнд 2 ажилд 28.5 сая, Зураг төсөлийн 8 ажилд 47.1 сая төгрөгийг баталсан. Нийт 28 ажлаас 13 ажил бүрэн хийгдэж дууссан.

- Сумын хоршоо хөгжүүлэх сангийн дансанд 2023 оны 07 дугаар сарын 30-ны байдлаар 42,928,024.00 / дөчин хоёр сая есөн зуун хорин найман мянга хорин дөрөв / төгрөгийн орлого төвлөрсөн байна. Жилийн орлогын төлөвлөөний биелэлт 85,8%, Муу зээлийн эргэн төлөлт 13,6 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

2022 оны зээлдэгч 1 /хэвийн/, 2021 оны зээлдэгч 3 үүнээс /1 муу зээлдэгч/, 2013-2019 оны 5 зээлдэгч / 5 муу зээлдэгч /. Дээрх муу зээлдэгч нарын өрийг ШШГГазартай хамтран барагдуулж байна. Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 17 дугаар тогтоолыг үндэслэн 06 дугаар сарын 01-ний өдрөөс 30 хоногийн хугацаанд ХХСангаас хөнгөлөлттэй зээлд хамрагдах төсөл хүлээн авах зар түгээсэн боловч шаардлага хангасан төсөл ирээгүй, 2023 оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөс 10 дугаар сарын 01-ний өдөр хүртэл товын дахин зарласан.

Байгаль орчин, хөдөө аж ахуйн ажлын хүрээнд:

- Сумын төвд Цаг уурын хяналтын бүс байгуулах ажилд зориулж 400 уртааш метр төмөр хайсан хашаа барьсан.

- Нийгмийн халамжийн ажлын хүрээнд сумын ажилгүй иргэдээр 10,000 м2 талбайн туурь хогийг цэвэрлүүлсэн.

- Иргэн Д.Мөнх-Эрдэнэтэй байгуулсан Төв хогийн цэгийг Ландфилл аргаар булшлах гэрээт ажил бүрэн хийгдэж дууссан. Тус ажлыг гүйцэтгэгч тал 2023 оны 08-р сарын 10-ны өдөр бүрэн хийж дуусган захиалагч талд хүлээлгэж өгөхөөр гэрээ байгуулан харилцан тохиролцсон.

- Намаржилтын ерөнхий нөхцөл байдал: Энэ намар 88 малчин, 72 мал бүхий өрхийн 72035 толгой мал намаржиж байна.

- Малчдад үзүүлж буй нийгэм, эрүүл мэндийн үйлчилгээ: Малчдад худалдаа, үйлчилгээ, шатах тослох материал зардаг ШТС, эрүүл мэндийн төвийн эмч эмнэлэгийн ажилтнууд тухай бүрд нь үйлчилгээ үзүүлж байна. Мөн эмийн сангийн үйлчилгээ, төрийн Е-Монгол хур системийн бүх төрлийн лавлагааны үйлчилгээ үзүүлэн ажиллаж байна.

- Отор нүүдэл, зөвшөөрөлгүй нэвтэрсэн өрх, малын тоо:Өвөрчингай аймгийн 2 өрхийн 2000 толгой мал отроор намаржиж байна. Зөвшөөрөл авсан отрын малчин байхгүй байна.

- Малын өвчний байдал, тайван эсэх: Одоогоор малын өвчлөл гараагүй тайван байна. Малын өвчнөөс сэргийлэх талаар Баянтал ХААТ группэд 2 удаа сэрэмжлүүлэг хүргэсэн

Бусад мэдээллийн хүрээнд:

- Сургууль: ЕБСургуулийн ажилчид Сургуулийн дотуур байрны өрөөнүүдийн эвдэрсэн эд зүйлсийг засан сэлбэх, хүүхэд хөгжлийн өрөөний дотор засвар, сургуулийн спорт заалны үүдний өрөө, заалыг засварлаж, ханыг будах ажлыг Сургуулийн үүдний тамбарын дээврийг засварлаж, борооны ус нэвтрэхээс хамгаалсан. Сумын ОНХСангаар Сургуулийн спорт, урлаг заалны 00-ын хийж гүйцэтгэсэн. Мөн Хичээлийн шинэ жил эхлэхтэй холбоотойгоор сургуулийн цэвэрлэгээг хийж гүйцэтгэж байна. гадна хашааны хөл газрын ургамлыг түүж, цэвэрлэсэн. Сургалтын ажлын хувьд: “Монголын физикийн багш нарын үндэсний сургалт, зөвлөгөөнд”, “Сургуулийн менежментийг сайжруулах нь” сургалтад хамрагдаж байна. Баянтал сумын ЕБСургууль нь өнөөдрийн байдлаар esis.edu.mn системд 154 сурагч бүртгэлтэй байгаа бөгөөд энэ хичээлийн жилд хамран сургах тойргоороо 1-р ангид шинээр элсэн 17 сурагч байгаа бөгөөд урьдчилсан байдлаар 171 суралцагчтай хичээллэнэ.

- Цэцэрлэг: 4 дүгээр цэцэрлэг нь хичээлийн шинэ жил эхлэх бэлтгэл ажлыг ханган дотоод засварын ажлыг 100% хийж дуусгасан бөгөөд одоогийн байдлаар дотоод ариутгал, цэвэрлэгээ үйлчилгээг хийж байна. 2-5 настай хүүхдийн бүртгэлийг 2023 оны 08 дугаар сарын 22-ны өдөр цахимаар болон танхимаар хүлээн авхаар ажиллаж байна.

- Эрүүл мэнд: Амбулаторийн үйлчилгээ: Нийт үзлэг-88, Амбулаторийн үзлэг-65 Үүнээс: Яаралтай түргэн тусламж - 12 хүн, Том хүн - 8, хүүхэд – 4, Идэвхитэй хяналт - 3 хүн, Өдрийн эмчилгээ – 1 хүн, Хэвтэн эмчлүүлсэн - 7 хүн, Өдрийн эмчилгээ – 0, Улаан бурхан, улаанууд урьдчилан сэргийлэх вакцинд 48 хүүхэд хамрагдсан байна. Товлолт вакцинд 6 хүүхэд хамрагдсан.

Сургалт, сурталчилгаа, хэлэлцүүлгийн хүрээнд:

<http://bayantal.gs.gov.mn/> цахим сайтыг шинэчилж, 10 мэдээллийг байршуулсан. Баянталын мэдээ паже хуудас нээн ажлуулж байна. Баянтал сумын Хурдан цэг интернэтгүй улмаас үйлчилгээ үзүүлж чадахгүй байна.

Хичээлийн шинэ жил эхлэхтэй холбоотой орчныг хаягдлыг цэвэрлэх мэдэгдэл хүргүүлээд байна.

ХЯНАСАН:

ГАЗРЫН ДАРГА

Б.ГАНБАЯР

МЭДЭЭГ НЭГТГЭСЭН:

ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ДАРГА

Ц.ЛХАГВАДОНИД